

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
“МОНГОЛ СУДЛАЛ”

Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть XLVIII (610)

DOI: 110.22353/ms20244806

МОНГОЛ ХЭЛНИЙ ОЙРОЛЦОО ӨГҮҮЛБЭРИЙН
НАЙРУУЛГЫН ОНЦЛОГ

Б.Мөнгөнцэцэг
Ц.Батдорж

Түлхүүр үг: өгүүлбэрийн найруулга, ойролцоо өгүүлбэр, тэгшлэх найруулга, эс тэгшлэх найруулга, юмжуулах ба дохиожуулах харьцаа

Хэлний нэгжүүд давхарлан шаталсан тогтолцоог бүтээхдээ ойролцоо ба эсрэг, төсөөт ба зүйлчилсэн утгатай байх ба эдгээр хэлний нэгжүүдээс үг, өгүүлбэр хоёрыг санаа бүтээх чухал нэгж хэмээн үздэг. Тухайн санааг яруу тодорхой болгон, уг хэлэх гэсэн санаагаа лавшруулан тодруулахын үүднээс ойролцоо өгүүлбэрийг найруулах ёсноо түгээмэл хэрэглэдэг. Б.Ринчен ойролцоо үгсийг хоршин хэрэглэхээс гадна, хос мөр бүтээдэг учрыг аман ба бичгийн хэлний жишээгээр харуулснаас ганц хоёрыг дурдвал,

*“Анчин гөрөөчин, авчин шувуучин
Шагайчин харвуулчин нийгэм бүхийгээр
Найр их цэнгэлд авцаръя гэж хэлжээ.*

Үхсэнийг мөрөөр үлдэж явсан

Хатсаныг мөрөөр хайж явсан

Зан муутын үр

Заяа муутын үхин гээшиб.

Санасан юмыг нь бүтээж хайрлагтуй


Сарвайсан юмыг нь тусалж хайрлагтуй (Ринчен, 1967:69-70)

гэхэд “анчин гөрөөчин (авчин шувуучин), шагайчин харвуулчин” найр цэнгэл гэсэн ойролцоо үгийг хоршсон бол “зан, санасан” хэмээх үгнээ дүрслэг утга бүхий “заяа, сарвайсан” хэмээх үгийг хоршсоныг хоёр мөр өгүүлбэр болгон толгой холбосон нь найруулгын нэг ур маяг болжээ. Мөн тэрээр “...зэрэгцэл байдлаар хэрэглэдэг хоршоо үг, тус тусдаа салаад, зэрэгцэл зүйр үгийн зүйл болж, үг найруулгад зэрэгцэл байдалтайгаар хэрэглэх нь цөөнгүй, ялангуяа туульсын найруулгад энэ тэр, чимэг хавсарсан зэрэгцэл үгийн байдалтай байдаг нь:

*“Хүн төөрөм хүдэн
Мал төөрөм манан”*

гэх манан хүдэн, хүдэн манан гэдэг хоршоо үгийг дэлгэрүүлэн зэрэгцэл үг шүлэг болгосон лугаа адил жишээ олон байдаг байна” гээд, эл үзэгдэл монгол хэлтэн ардын аль ч аман аялгуунд байдаг болохыг дурджээ.

Нийлмэл өгүүлбэрийн гол зангилаа зүйл нь тэдгээрийн зааг буюу холбох хэрэглүүр юм. Өгүүлбэр нь заагт байгаа нэгжүүдээр зэрэгцэж угсарч холбогдохоос гадна тухайн өгүүлбэрүүдийн үндэс давтагдах, эсрэгцэх эсвэл ойролцоо ба төсөөтэй болох зэргээр хоорондоо холбогддог. Үүнтэй монгол хэлний өгүүлбэрийн найруулгын сондгойруулахгүйн ёс нарийн холбоотой байдаг. М.Базаррагчаа, Ж.Баянсан нар өгүүлбэрийн найруулгыг хэлбэр¹ ба агуулгын хувьд ялган үзсэн байна. Тодруулбал, агуулгын хувьд “ойролцоо ба төсөөт өгүүлбэр нь ижилсэлд, эсрэг ба зүйлчилсэн өгүүлбэр нь ондоошилд тус тус тулгуурлана” гэж үзээд, өгүүлбэрийг хэлбэрийн талаас нь тэгшлэх ба эс тэгшлэх гэж хоёр ангилсан байна (1997:63). Үүнд:



Хэлэн дэх ойролцоо нэгж нь утга, хэлбэрийн олон талтай бөгөөд монгол хэлний ойролцоо өгүүлбэрийг утгын хувьд, юмжуулах (бодит) болон дохиожуулах² (хийсвэр) харьцааны үүднээс ялган үзэж болно. Харин хэлбэрийн хувьд М.Базаррагчаагийн үзсэнчлэн тэгшлэх, эс тэгшлэх хоёр янз байна. Түүнчлэн ойролцоо өгүүлбэр нь ойролцоо утгат гишүүдээс³ гадна илтгэж буй санаагаараа ижилсэн бүтсэн байна. Үүнд:

А. тэгшлэх	I. бодит ойролцоо өгүүлбэр \\уг үйл явдал нь нэг\\ 1. Ухаан нь ууцандаа Санаа нь сүүжиндээ 2. Уулын бартааг явж мэднэ Усны гүнийг гаталж мэднэ	II. хийсвэр ойролцоо өгүүлбэр \\үйл явдлын тухай санаа төстэй\\ 1. Өргөвч өөдлөхгүй Тэтгэвч дэгжихгүй 2. Морь эцэвч эмээлээ даана Мод эцэвч мөчрөө даана
Б. эс тэгшлэх	1. ...нүхнээс гарч хошихрох тарвагыг ч бараг таних бөгөөд нисэн өнгөрч одох шувууг ч төлөв мэднэ (Д.Нацагдорж) 2. ...түмэн баатар эрсийн боловч зүрхийг чичрүүлэн догдлуулж, төв эрдэмт оюунтны боловч хүслийг холбилзуулан татна. (Д.Нацагдорж)	1. Хоёр хүн довцог дээр гараад холыг ширтэн, алсыг ажна. (Ч.Чимид) 2. Үүнээс үзвэл, цөм Цэрмаагийн хийсэн ба болгосон идээ мөн. ...Цэрмаа гал тогоотой хуримлана. (Д.Нацагдорж)

¹ “хэлбэр” гэдгийг “хэл зүйн ижил төстэй бүтэц” гэсэн утгаар хэрэглэв.

² Юмжуулах буюу бодит утга нь хэлний бус үйл ба хэрэг явдлын тухай үнэн мэдээлэл агуулдаг бол дохиожуулах буюу хийсвэр утга нь ертөнцийн юмсын тухай мэдээлэл хүний ухамсарт хэрхэн илэрч буйг илтгэнэ.

³ Монгол хэлний ойролцоо үгийг агуулга ба хэлбэр, зогсонги хөдлөнг талаас туйлын, оновчтой, оновчтой бус, хуурмаг ойролцоо үг гэж ангилсан ба ангилал тус бүрийг бодит ба хийсвэр утгын талаас ялган авч үзсэн болно (Базаррагчаа, Мөнгөнцэцэг, 2012:32).

Бодит ойролцоо өгүүлбэр: Бодит утгын талаас, ойролцоо өгүүлбэр нь нэг санааг илтгэхдээ ойролцоо үг, зүйлийн үгээр ялгарч, бодит үйл явдлыг давтсан байна. Жишээ нь:

1. Ухаан нь ууцандаа

Санаа нь сүүжиндээ гэсэн өгүүлбэрийг бүтээж буй гишүүн нь “ухаан-санаа” гэсэн хийсвэр утга бүхий оновчтой ойролцоо үг⁴, “ууц-сүүж” хэмээх хүний зүйлийн нэрээс бүтэж, “унхиагүй, доожоогүй” гэсэн санааг агуулжээ.

Үг гэвэл тогтоогоод ав

Үсэг гэвэл цээжлээд ав гэсэн өгүүлбэрийг бүтээж буй гишүүн нь “цээжлэх-тогтоох” бодит утга бүхий хуурмаг ойролцоо үг⁵, “үг-үсэг” хэмээх хүний бүтээсэн зүйлийн нэрээс бүтэж, “сурсан бүхэн эрдэм” гэсэн санааг агуулжээ.

2. *Арван гурван наснаас тавин зургаан насыг хүртэл Шарын гол ба Улаанбаатар хоёрын хооронд Дагвын өвсийг зөөж, Балдангийн түлээг тээсээр өдий хүрсэн тул зам дахь уул давааг ч андахгүй, энхэл донхлыг ч эндэхгүй, нүхнээс гарч хошихирох тарвагыг ч бараг таних бөгөөд нисэн өнгөрч одох шувууг ч төлөв мэднэ (Д.Нацагдорж)* гэхэд “бараг-төлөв”, “таних-мэдэх” гэсэн хийсвэр утга бүхий оновчтой ойролцоо үг, “нүхнээс гарч хошихирох-нисэн өнгөрч одох, тарвага-шувуу” зэрэг зүйлийн үгсээр бодит үйл явдлыг давтсан байна. Тодруулбал, энэхүү өгүүлбэрт өгүүлэхүүнийг ойролцоо гишүүнээр ижилсүүлж, өгүүлэгдэхүүн, шууд тусагдахууныг зүйлчлэн ондоошуулсан байна.

Тэнгэрийн хаяанаас чинаги газар байдгийг мэдэж, таван далай таван тивийг танин шинэ ертөнц дээр хамт явах замыг нээв. (Д.Нацагдорж) гэхэд “таних-мэдэх” гэсэн хийсвэр утга бүхий оновчтой ойролцоо үг, “газар-тив” зэрэг зүйлийн үгсээр бодит үйл явдлыг давтсан байна. Тодруулбал, энэхүү өгүүлбэрт өгүүлэхүүнийг ойролцоо гишүүнээр ижилсүүлж, шууд тусагдахууныг зүйлчлэн ондоошуулсан байна.

Бодит утгын талаас, нэг санааг илтгэхийн тулд тухайн ойролцоо өгүүлбэрээр бодит үйл явдлыг давтан, эс адилтган бүтээсэн байна.

1. Уулын бартааг явж мэднэ

Усны гүнийг гаталж мэднэ гэхэд “ямар нэг хэргийг бүтээхэд саад бэрхшээл тохиолддог” хэмээх санааг илтгэхдээ сонгож авсан гараг ертөнцийн зүйл (уул-ус) нь бодитой байхын зэрэгцээ эс адилтган өгүүлсэн тул бодит ойролцоо өгүүлбэр болно.

Зэвсэгт эрийг айлгаж

Зэв тоногийг булаадаг

Илдэт эрийг няцааж

Илүү дутууг булаадаг гэхэд “зорьж буй үйлээс нь, эсвэл сэтгэлийн их хүчийг нь алдагдуулан шантраах” хэмээх санааг илтгэхдээ “зэвсэг-ерөнхий, илд-тодорхой”, “зэв тоног-тодорхой, илүү дутуу-ерөнхий” гэсэн ерөнхий-тодорхой

⁴ Ойролцоо үгийн нийлэх утганцар нь олон, ялгарах утганцар нь цөөн бол тэдгээрийн утга ойртох тул хийсвэр утга бүхий оновчтой ойролцоо үг болно.

⁵ Тухайн эхэд төрөл (род) зүйл (вид)-ийн харьцааг илтгэж, утгын ялгаа нь бүдгэрч саармагшсан бол бодит утга бүхий хуурмаг ойролцоо үг болно.

утгат бодитой юм (хүний бүтээсэн зүйл)-ыг сонгон авсны зэрэгцээ бодит ертөнцийн үйл явдалтай тохирч буй тул бодит ойролцоо өгүүлбэр болно.

2. *Нэгэн залуу хүүхэн жолоог дугтран зүтгүүлсээр гарч ирэхүй нь зэрлэг бугын адил өнгөтэй ба цог заль гэрэлтэн, жавхлантай нь түмэн баатар эрсийн боловч зүрхийг чичрүүлэн догдлуулж, төв эрдэмт оюунтны боловч хүслийг холбилзуулан татна (Д.Нацагдорж)* гэхэд хүний зүйлийн нэр (баатар эр-эрдэмт оюунтан)-ээр бодит үйл явдлыг давтахын зэрэгцээ эс адилтган нэг санааг илтгэж буй тул бодит ойролцоо өгүүлбэр болно.

Хэдийгээр ухаан сэргэлэн хэмээвч, зүүн хошууны зах дор хүрсэн үгүй, баруун мөрний тэртээ гарсан үгүй, зөвхөн гурав дөрвөн өртөө эргэн тойрон газрын дотор оршин суусан тул, юуг үзэж мэдэж, юуг олж сонсох ажээ. (Д.Нацагдорж) гэхэд зүйлийн үг (хошуу-мөрөн)-ээр бодит үйл явдлыг давтахын зэрэгцээ эс адилтган нэг санааг илтгэсэн байна.

Хийсвэр ойролцоо өгүүлбэр: Хийсвэр утгын талаас, тухайн ойролцоо өгүүлбэрийн гишүүд нь ойролцоо үгээр ялгарч, улмаар ойролцоо санаа илтгэнэ.

1. *Өргөвч өөдлөхгүй*

Тэтгэвч дэгжихгүй гэсэн өгүүлбэр нь “өргөх-тэтгэх”, “өөдлөх-дэгжих” гэсэн хийсвэр утга бүхий оновчтой ойролцоо үг бүхий гишүүдээр ижилсэн холбогдож, “а. сэхэл засал авахгүй, унхиагүй, б.хүний тус мэдэхгүй” гэсэн санаа илтгэжээ.

Санасаар суугаад саарал

Бодсоор суугаад буурал гэсэн өгүүлбэр нь “санах-бодох” хийсвэр утга бүхий оновчтой ойролцоо үг (гишүүн), “буурал-саарал” хийсвэр утга бүхий оновчтой бус ойролцоо үг⁶-ээс бүтэж, “ажил үйлс нь бүтэмжгүй, юм хийдэггүй” гэсэн санааг илтгэжээ. Тодруулбал, “буурал болох-саарал болох” нь “хөгшрөх” гэсэн утгыг үсний өнгөөр нь төлөөлүүлсэн тул хийсвэр утга бүхий оновчтой бус ойролцоо үг болно.

2. *Хоёр хүн довцог дээр гараад холыг ширтэн, алсыг ажна. (Ч.Чимид)* гэсэн өгүүлбэрт буй “алс-хол”, “ширтэх-ажих” нь хийсвэр утга бүхий оновчтой ойролцоо үг болно. Тодруулбал, “ширтэх-ажих” нь харааны эрхтнээр мэдрэх үйлийг заах боловч “ширтэх” нь нарийвчлан харах, “ажих” нь анхаарч харах гэсэн утгын нарийн ялгамжтай байна.

...өдрийн өнгөрлийг түмэн удаа эргэцүүлэн санаж, мянга дахин мөрөөдөн хүсэхийн дээр... (М.Ядамсүрэн) гэхэд “түмэн удаа-мянган дахин” нь бодит тоон утгаараа адилгүй ч тухайн хам сэдэвтээ “олонтоо” гэсэн утга илтгэх бодит утга бүхий хуурмаг ойролцоо үг (зүйл-зүйл), “санах-хүсэх” нь хийсвэр утга бүхий оновчтой ойролцоо үг (гишүүн) болно.

Хийсвэр утгын талаас, ойролцоо санааг илтгэхийн тулд бодит санааг хийсвэр санаатай ил ба далд адилтган, улмаар ойролцоо өгүүлбэр бүтээнэ.

⁶ Нэг үгийн гол ба салаа утга нь нөгөө үгийн гол ба салаа утгатай ойролцоо байж, дүрслэх ур маягаар бүтсэн бол *хийсвэр утга бүхий оновчтой бус ойролцоо үг* болно.

1. *Морь эцэвч эмээлээ даана*

Мод эцэвч мөчрөө даана гэхэд хүний тухай өгүүлсэн “а. өтөлснөөс үхсэн биш, б.чоно өтлөвч ишгэндээ, цорж өтлөвч балиндаа” гэсэн хийсвэр санаа нь хоосноор илэрсэн ба уг хийсвэр санааг “мод, морь” хоёрыг адилтгасан хоёр өөр бодит үйл явдлаар далд адилтган, хийсвэр ойролцоо өгүүлбэр бүтээсэн байна.

Хүн ёс дагана

Нохой яс дагана гэхэд хоёр өөр санаатай боловч нэгдүгээр өгүүлбэрийн хийсвэр санааг хоёрдугаар өгүүлбэрийн бодит санаатай ил адилтгаж, “ёс ёмбогор, төр төмбөгөр” гэсэн ойролцоо санаа бүхий өгүүлбэр бүтээсэн байна. Тодруулбал, дагалт өгүүлбэр нь хүний тухай өгүүлсэн өгүүлбэрийн санааг чимэхийн дээр адилтгуулагч болсон байна. _

2. “Ингээд богдын хүрээний гуйлгачны тоо нэгээр өсөж, баатар зоригт гэгдэж байсан хуяг таяг тулсан гуйлгачин болов” гэхэд эхний өгүүлбэр нь гуйлгачин болсон тухай ерөнхий санааг заасан бол дараагийн өгүүлбэр нь мөн үйл явдлын тухай тодорхой санааг өгүүлжээ. Иймд энэ хоёр өгүүлбэр нь ойролцоо санаа илтгэж байна.

Үүнээс үзвэл, цөм Цэрмаагийн хийсэн ба болгосон идээ мөн. Гэрийн эзэд шинэ хувцсыг өмсөөд, битүүлнэ хэмээн баяртай жавхлантайгаар хөдөлцгөөнө. Цэрмаа гал тогоотой хуримлана. (Д.Нацагдорж) гэхэд Цэрмаагийн хийж болгосон идээг гал тогоогоор нь солин нэрлэхийн зэрэгцээ түүнийгээ “...хуримлах” гэж амьдчилан адилтгаснаар энэ хоёр өгүүлбэр ойролцоо санаатай өгүүлбэр болжээ.

Өгүүлбэрийн найруулга нь гүн бүтэцтэйгээ шүтэлцээтэй бөгөөд хэлэхийн цуваа буюу тухайн эхэд утга, хэлбэрийн олон тооны хувилбарууд аяндаа үүсдэг байна. Жишээ нь:

I. “Хүн ямарваа нэг юманд арга мухардавч яг тэр мөчид арга ухааныг нь сэтгэж олох хэрэгтэй” гэсэн санаа бүхий “*Нохой хамартаа хүрэхээр усч, хүн аминдаа тулахаар аргач*” гэсэн ойролцоо өгүүлбэр нь адилтгагдахуун, адилтгахуунаар илрэхийн сацуу ихэнхдээ адилтгагдахууныг гээж, адилтгахуун (нохой хамартаа хүрэхээр усч)-аар илрэх нь элбэг байна. Учир нь, олон янзын тохиолдолд хэрэглэх боломжийг олгодог байна (олон зүйлд холбогдуулан хэлж болно). Тухайлбал: “*Далайд дусал нэмэр (давсанд шүү нэмэр); Дайны хажуугаар дажин (даамлын хажуугаар гүймэл); Гэмт хүн гэлбэлзэнэ (даарьт морь дайвалзана); Номхон тэмээг ноолоход амар (Ноомой хүнийг зарахад амар)*” гэх зэрэг адилтгагдахуун болон адилтгахууны аль нэг нь хоосноор илэрч, заавал хэлэх шаардлагагүй тохиолдолд монгол хүн маш сайн ойлгодог жишээ олныг дурдаж болно.

II. Эцсийн үйл өгүүлэхүүнийг хурааж хувиргах. Тухайлбал, “*Хүн болох багаасаа, хүлэг болох унаганаасаа*” гэсэн ойролцоо өгүүлбэрийн хураасан өгүүлэхүүнийг “Хүн болох багаасаа танигдана” гэж сэргээвэл, “ямар хүн болох нь удам угсаанаас шалтгаалдаг, багын хүмүүжилтэй холбоотой” гэсэн санаа илтгэнэ. Харин “Хүн болох багаасаа эхэлнэ, шалтгаална, нөхцөлдөнө” хэмээн сэлгүүлбэл “Хүүхдийн хөгжил хүмүүжилд өсөж бойжсон орчин ахуй чухал нөлөөтэй” гэсэн санааг илэрхийлнэ. “*Хаанаасаа хаалгач нь, богдоосоо боол нь*” гэсэн өгүүлбэрт

үнэхээр “хаанаасаа хаалгач нь ширүүн” гэсэн утгатай нь мэдрэгдэх боловч зарим тохиолдолд дээд тушаалтнаасаа доод тушаалтай нь илүү тустай гэсэн санаагаар хэрэглэдэг” (Гаадамба, 1987, 37)

Дээлгүй нүцгэн

Дэлэвчгүй шалдан

Сэтгэлийн цээр

Санааны сэв” гэх мэтээр дан нэрлэсэн өгүүлбэрээр илрэх нь бий. Ийнхүү аман болон бичгийн зохиолд хэлэх санааг өгүүлбэр, цогцолборын бүтэц, түүний олон сэлгээ хувилбараар илэрхийлэхдээ тэгшлэн сондгойруулахгүй байх, түүнчлэн санааг онцлон ялгахын үүднээс утга - хэлбэрийн хувьд сондгойруулах эс тэгшлэх төдийгүй, гишүүдийг олшруулах, тонгоргох зэрэг олон аргыг хэрэглэдэг байна. Гагцхүү утга санаа, хэлбэр бүтэц хоёр нь зүй зохист харьцаанд байх ёстой ажээ.

Монгол хэлний ойролцоо өгүүлбэр нь тэгш хэмт найруулга бүхий цогцолбор бүтээхэд гол үүрэгтэй бөгөөд зөвхөн яруу найрагт бус, туульс, жүжиг, кино зохиолд ярианы хэлбэрээр өргөн хэрэглэгддэг. Үүнийг тус бүрд нь тодруулан авч үзье.

Яруу найраг дахь ойролцоо өгүүлбэр:

Зэвсэгт эрийг айлгаж

Зэв тоногийг булаадаг.

Илдэт эрийг няцааж

Илүү дутууг булаадаг. (*Чингис хааны Наймантай байлдсан домог*) гэсэн хэсэгт “довтлох ба хамгаалахад чухал хэрэгцээтэй хэрэгсэл” болох “зэвсэг (ерөнхий) –илд (тодорхой), “зэв тоног (тодорхой) - илүү дутуу (ерөнхий)” гэсэн ерөнхий - тодорхой утга бүхий үгийг салаавчлан найруулахын сацуу үгийн сангийн үндсэн утгаараа “айлгах” нь “айх сэтгэл төрүүлэх, эмээлгэх”, “няцаах” нь “зогсоох, тогтоох, буцаах” гэсэн утга илтгэдгээрээ ялгаатай боловч тухайн хам сэдэвтээ “зорьж буй үйлээс нь, эсвэл сэтгэлийн их хүчийг нь алдагдуулан шантраах” гэсэн утга илтгэх тул хуурмаг ойролцоо үг болно.

Гэгээвчин дор үүрээ барьдаг

Голын хараацай хөөрхийлэлтэй

Учирсан дор үгээ хэлдэг

Гэнэн бүсгүй өрөвдөлтэй. (*Б.Явуухулан*)

Энэ хэсэгт шүлгийн хоёр дахь дүрслэгдэхүүний талаар уншигчдад ямар нэг төсөөлөл төрүүлэх үүднээс амьтны амьдралын нэгэн онцлог байдлыг эхлэн өгүүлж, хүний амьдралтай зэрэгцүүлжээ. Тодруулбал: Гэгээвчин дор үүрээ барьдаг голын хараацай, учирсан дор үгээ хэлдэг гэнэн бүсгүй хоёрыг “гэнэн хонгор бодлогогүй өрөвдөлтэй байдал”-аар нь адилтган, ойролцоо өгүүлбэр бүтээсэн байна. Ийнхүү хэлний нэгжүүдийг оновчтой зөв сонгож холбох явцдаа монгол хэлний найруулгын эс сондгойруулах зарчим, тэгшлэх ёсыг сайтар баримтлан, цогцолборыг ойролцоо өгүүлбэрээр ижилсүүлэн найруулсан нь олонтоо байна. Дараах зохиомжийн зүйлүүдэд илэрч байна. Үүнд:

а. Хөрөг дүр: “...Бас тэдний хойноос өлссөн шувуу мэт өрвөлзөн сөрвөлзөн ирэгчид хэн бэ?” гэж Таян хан асуувал, Жамуха хариу өгүүлрүүн:

“Тэр хойноос ирэгч нь

Тэмүжин анд мөн байна.

Хан Тэмүжин тэр

Хамаг биедээ цөм

Шөвөг хатгах зайгүй

Шөрөг төмөр өмсөж

Зүү шивэх завсаргүй

Зүймэл хуяг өмсөж

Өлссөн шувуу мэт

Өрвөлзөн сөрвөлзөн айсуу

Уурласан араатан мэт



ойролцоо өгүүлбэр

Урагш дүүлэн айсуу” (Чингис хааны наймантай байлдсан домог) зэргээр тоочин зурагласан нь Чингис хааны гадаад дүр төрх, өмсгөл зүүлтийн хөрөгчлөл бөгөөд уг зохиол дахь хөрөг дүрийн бүрдэл хэсгийн дүрслэлд ойролцоо өгүүлбэрийг илтгэж буй санаагаа лавшруулан тодруулах зорилгоор сонгосон нь “шөвөг хатгах нь бүү хэл зүү ч шивэх завсаргүй” хэмээх хэтрүүлгийн аргаар илэрч байна. Мөн “хатгах – шивэх”, “зайгүй – завсаргүй” гэх ойролцоо үг, “шөвөг – зүү” гэх хүний бүтээсэн зүйлийн үгээс бүтсэн бол хуягийг бүтсэн эдээр нь төлөөлүүлж “шөрөг төмөр” гэж тодотгон дүрсэлжээ.

б. Захидал: *Эцгийн минь сургаал тэр.*

Өвгийн минь гэрээс тэр.

Эрхэм сургаал үүнийг

Эндэлгүй дагахаар

Саваагүй холыг зорьсон тул

Сааралгүй эрдмийг хичээх чухал.

Аюулгүй алсыг давсан тул

Алжаалгүй номыг үзэх чухал. (Ц.Дамдинсүрэн)

“Шууд уншигчдад зориулан захидал маягаар зохиомжлох арга туурвил зүйд үлэмж дэлгэрсэн (Галбаатар, 2002, 98) бөгөөд дээрх цогцолборт баатрын санаа бодлыг нээхдээ санаагаа онцлон хүчжүүлэх, лавшруулахын үүднээс ойролцоо өгүүлбэрээр ижилсүүлж найруулжээ.

в. Байгалийн зураглал:

Улаан хадны ёроолоор

Ногоон модны дундуур

Урсаж байгаа мөрнийг

Уулан дээрээс харахад

Ургамал сайхан мод мэт

Мөчирлөн салбарлан харагдана.

Урт хөх могой мэт

Мурилзан мушгиран үзэгдэнэ (Ц.Дамдинсүрэн) гэсэн байгалийн

зураглал бүхий хэсэгт уянгын баатрын сэтгэл хөдлөлийг илтгэх үүднээс ойролцоо өгүүлбэрээр санаагаа онцлон бүтээжээ. “Харах - үзэх” гэсэн ойролцоо үг нь олонх утганцраар таарч, цөөн утганцраар ялгарсан тул хийсвэр утга бүхий оновчтой ойролцоо үг болох бөгөөд “үзэх” нь “нягтлах” гэсэн утгатай юм.

Монгол хэлний ойролцоо хэлц өгүүлбэр нь яруу найрагт эшилсэн, зохиосон хэлбэрээр тохиолдож байна. Үүнд:

а. Эшилсэн нь:

Эмээлээсээ өндөр даваа даваагүй

Эхнэрээсээ ондоо хүнтэй танилцаагүй (ойролцоо хэлц өгүүлбэр)

Эхнэрээсээ ондоо хүнтэй танилцаагүй

Эмээлээсээ өндөр даваа давалгүй

Айлаасаа бусдын үүдийг таталгүй

Ахаасаа бусдын занг мэдэлгүй (Ц.Дамдинсүрэн)

б. Зохиосон нь:

Үзэхэд үрчгэр

Харахад харчгар (ойролцоо хэлц өгүүлбэр)

Харахад царайгүй харчгар

Үзэхэд үзэмжгүй үрчгэр (Монгол ардын тууль)

Үргэлжилсэн үгийн зохиол дахь ойролцоо өгүүлбэр: Найруулгын утгын ялгааг гаргахад ойролцоо ба төсөөт, эсрэг ба зүйлчилсэн бүтээвэр, үг, өгүүлбэр, цогцолборыг зөв бүтээх нь чухал юм. Тухайлбал,

Арван гурван наснаас

Тавин зургаан насыг хүртэл

Шарын гол ба

Улаанбаатар хоёрын хооронд

Дагвын өвсийг зөөж

Балдангийн түлээг тээсээр

өдий хүрсэн тул

Зам дахь уул давааг ч андахгүй

Энхэл донхлыг ч эндэхгүй

Нүхнээс гарч хошхирох

тарвагыг ч бараг таних бөгөөд

нисэн өнгөрч одох

шувууг ч төлөв мэднэ (Д.Нацагдорж)

} зүйлчилсэн өгүүлбэр

} ойролцоо өгүүлбэр

} ойролцоо өгүүлбэр

гэсэн цогцолборт тэрэгч Лувсангийн дөчин гурван жилийн хэрэг явдлыг маш оновчтой хураан өгүүлсэн нь ойролцоо өгүүлбэр (ижилсүүлэх), зүйлчилсэн өгүүлбэр (ондоошуулах)-ийг чадмаг хослуулсанд оршино. Тодруулбал, “зөөх-тээх, уул даваа- энхэл донхол, андахгүй- эндэхгүй, бараг- төлөв, таних- мэдэх” гэсэн ойролцоо ба хувилбар үг, “13- 56, Улаанбаатар- Шарын гол, Дагвын өвс- Балдангийн түлээ, нүхнээс гарч хошхирох- нисэн өнгөрч одох, тарвага- шувуу” зэрэг зүйлийн үгсийг зэрэгцүүлж, санаагаа гүнзгийрүүлсэн байна. Ийм жишээ олныг дурдаж болно.

Одоо Занданбалыг хэн санах билээ. Чухам	
<u>мартагдсан</u> <u>“хорвоо”</u>	<u>орхигдсон “орчлон”</u> $\Longrightarrow$ ойролцоо өгүүлбэр
хэмээх ёсоор бүрэн хөсөрдөж маргааш үхэх өнөө үхэх нь Занданбалын ганц бие дэх хувийн хэрэгт “нэгэн биений зовлон тул”	
<u>дээш тэнгэр хол</u>	<u>доош газар хатуу</u> $\Longrightarrow$ эсрэг өгүүлбэр
гэдэг монголын хуучин үлгэрээр хэлэх газар гомдох нөхөргүй нэгэнт өнгөрсөн улирлын дотор хоцров (М.Ядамсүрэн).	

Хөрөг: “Тэр нэгэн элэг эмтрэх эцсийн өдөр эрүүл сайхан бие чинь эрэмдэг болж инээхээс биш өвчтэй, эвиэхээс илүү чадалгүй болоод эргээж нэг бодоход эртээс үлдсэн эдгүй итгэлээр нийлсэн хань үгүй эцэстээ тэжээлгэх үргүй гэрт орвол хүйтэн гэдсэн дотор өлсгөлөн, гэмгүй атал хараагдаж, зэмгүй атал жигшигдэж хөөрхөн гоо царай чинь хөгшин бухын дух мэт үрчийж, нарийн гол шиг бие чинь хохь цагаанаар хатаж хоёр хөлөөрөө туйваад намирхан хар үс чинь навтас эсгий мэт ширэлдээд хасын шулуун хамраа ханын хээтэй булигаараар нөхөж, урлаг хоёр нүд чинь улаан зовхиороо эргэлдэж усан бүрхээсээр хөвөлзөөд хүн олны нүдний хог, шүдний мах мэт хаягдаж хөөрхий хэмээх хөнгөлөлтгүй, зайдуул хэмээх завсаргүй, өрөвдөж туслах өршөөлгүй өнөд гутамшигийн туйлыг хүлээж, өндөр хогийн өвөр, өргөн зээлийн булан өмхөрсөн хүрдний ёроолыг хэсэж хэвтэх цагт өсгөж хүмүүжүүлсэн эцэг эх, өршөөж удирдсан нам засгийн сургууль, үүрдэд хамтарсан үнэн нөхөр үхэхэд эргэх үр хүүхдээс эхлэн элдэв нэгэн үнэн зөв бүр санагдаж гаслах бөгөөд холыг бодож хожмыг сануулсан Хоролмаа би хүртэл санагдахад хүрнэ (М.Ядамсүрэн)” гэсэн нь Занданбалын гадаад дүр төрх, зүс царай, үйлдэл, зан төрхийн хөрөг бөгөөд санаагаа онцлох үүднээс найруулгын тэгш хэмт зарчмыг барьж, ойролцоо өгүүлбэрээр ижилсүүлэн найруулсан аж.

Дотоод яриа: “Ороо нь ороогоороо, жороо нь жороогоороо гэдгийн үлгэрээр харин нэг таарсан хэд нийлээд наргиж байгаа юм байна даа гэж бодсоор Халтар тэднийг харж хэдэн минут хий дэмий зогслоо” (Ц.Уламбаяр); “Ажилд бие цуцах нь гайгүй боловч болохгүй юм шүү гээд байхад бодогдоод байдаг хонгор хэцүүеэ. Санасаар суугаад саарал, бодсоор суугаад буурал” гэгч болох нь гэж бодоод гэнэтхэн нэг ухаан олов” (Ч.Чимэд). Энэхүү сэтгэлдээ ганцаарчлан ярих дотоод яриаг хүчжүүлэх, батлах зорилгоор ойролцоо өгүүлбэрийг “гэ-” язгуурт үйл үгээр холбон эшилсэн байна.

Энэ мэт найруулах ур маягт санаагаа ахиулан лавшруулах зорилгоор тэгш хэмт найруулга бүхий ойролцоо өгүүлбэрийг сондгойруулах зарчим буюу эс тэгшлэх найруулгатай хослуулсан нь оновчтой болжээ. Жишээ нь: “Тиймийн тул даруй мориноос бууж суун, түмэнтээ сочиж, мянгантаа хирдхийн, хэзээ нар мандахыг хүлээнэ” (Д.Нацагдорж); “Иийшээ ширтэж, тийшээ гөлрөн, үүнийг гайхаж, түүнийг бодсоор явтал, олон морьтой хүмүүсийн дундуур нэгэн сайхан саарал морины толгой тэмүүлэн, ам нь ангалзаж, хоёр чих нь солбилзон үзэгдэхэд хэдийн миний хоёр нүд гэрэлтэн туссан бөгөөд нэг залуу хүүхэн

жолоог дугтран зүтгүүлсээр гарч ирэх нь хувилгаан охин адил гэрэлтэй ба цог заль өнгөтэй, жавхлантай нь түмэн баатар эрсийн боловч зүрхийг чичрүүлэн догдлуулж, төв эрдэмт оюутны боловч сүнс /хүсэл/-ийг холбилзуулан татна” (Д.Нацагдорж); “Тэрхүү зовлонд эрсдэж, гасланд нэрвэгдэх гайхааш барагдсан цагт чи хэдий түмэнтээ гэмшиж, мянгантаа гашиудах авч чиний улирал нэгэнт өнгөрсөн байх тул хүлээх зовлонгоос хэлтрэхүйеэ нэн бэрх амуй. (М.Ядамсүрэн); “Хөлд орохоос аваад үс цайхыг хүртэл нэг голыг өгсөн уруудан нүүж, нэг худгийг эргэн тойрон нутагласаар, энэхүү ертөнцийг эцэслэнэ” (Д.Нацагдорж).

Монгол хэлний ойролцоо хэлц өгүүлбэр нь үргэлжилсэн үгийн зохиолд мөн өшигдсэн, зохиосон 2 хэлбэрээр тохиолдож байна.

а. **Эшилсэн нь:** “Нэг явдал болох нь болох л вий. Ер нь л нэг биш над шиг хөгшин нь сайн муу явдлын хөлд үрэгдэж гишгүүлчихгүй байх, чам шиг залуу нь сайн үйлсээс нь хоцорч шившиг болохгүй бол хэрэг сэн. “Даравч дардайна, булавч будтайна” гэгчээр номтой эрдэмтэй улс нэмэгдэж, ухаантай, хөрөнгөтэй нь хол ойрын юм үзэж мэдэж юм л гээч болж байна” (С.Удвал).

“Яах вэ жанжсин бид хоёр хэдий барсын аманд оровч, Тайшин уул шиг амгалан байна. Харин, бидний дараа эрхэм На ван- еэ, Богдын аварлаар их хэргийг төгсгөж, амбанд бараалхвал зохих биз ээ. Эртний үгэнд эзний алба ээлжтэй, хааны алба халаатай гэдэг билээ” (Б.Ринчен).

б. **Зохиосон нь:** Найруулгын онцлог, эсвэл үйл явдал, зохиомж зэргийг дуурайн зохиосон байна. Тухайлбал, “Амьд явбал алтан аяганаас ус ууна, мэнд явбал мөнгөн аяганаас ус ууна” гэсэн ойролцоо өгүүлбэрийн яриа бичигт түгээмэл хэрэглэгддэг “Амьд явбал алтан аяганаас ус ууна” гэсэн бэлэн хэлц өгүүлбэрийн санаа болоод хэлбэрийг тухайн өвөрмөц байдалд зохицуулан Д.Нацагдорж “Эрүүл явбал улсын наадмыг үзнэ” хэмээн зохиож цогцолбор бүтээсэн байна.

Жүжгийн зохиол дахь ойролцоо өгүүлбэр: Тодорхойлол: “Мөнх- Очир: Төр нялхдаа хатуу. Би гэвэл сэтгэл зөөлөн, гар харамч, аливааг тэмцлээр биш, эв эвлэрэлтээр хийхийг хичээнэ. Бас яарахаас айна. Яарсан юм түүхий болж, эцэстээ чиний миний буруу гэж бие бие рүүгээ түлхэхийн уурхай болдог. Иймд би хийхээсээ бодох минь их, хэлэхээсээ дуугүй өнгөрөх нь олон. Ийм хүн одоо цагт яавч таарахгүй” (Д.Намдаг); “Осол- Одоо яая гэх вэ, дэмий нэрэлхэлт. Би ер нь нэрэлхүүгийнхээ хувьд нэрд гарсан хүн. Энэ маань үнэндээ өлсгөлөн цагт цатгалан юм шиг, даарсан цагтаа халууцсан юм шиг байхыг ямагт боддогоос болж байгаа юм. ...” (Д.Намдаг) зэргээр өөрийн зан чанар, байр сууриа илэрхийлж байгаа нь тухайн баатрын зан төрхийн нэг маягийн тодорхойлол⁷ бөгөөд үүндээ ойролцоо өгүүлбэрийг санаагаа лавшруулах үүднээс ашигласан байна.

⁷ Тодорхойлол (гр. charakter)- Уран зохиолын баатрын зан төрх, онцлог шинжүүдийг баатрын өөрийнх нь үг хэлээр илэрхийлэн гаргах зохиомжийн нэг зүйлийг тодорхойлол гэнэ (Галбаатар, 2002, 268).

Үглэл яриа: Д.Намдагийн “Жаргалт эх Оролмаа” жүжгийн төгсгөлд “...
Үгүйрэлд нэрвэгдсэн эх, юу юуны урьд үр хүүхдээ тэжээхийн төлөө амь бие
хайргүй зүтгэн зүтгэсээр гарыг нь ганзаганд, хөлийг нь дөрөөнд хүргэж чадсан
тухайдаа энэ дэлхийд хүн болж төрсний минь гавьяа энэ ээ гэж бахархдагаа.
Ингэхэд эх миний сэтгэл эгээ л тэднийхтэй адил аа. Харин ч би энэ удаад
үзээгүйгээ үзэн, бодоогүйгээ бодоход хүрснийхээ завшаанд өнгөрч байгаа үеийн
жирийн нэгэн эх байснаасаа өнөө цагийн шинэ эх болохоос өөр замгүй болсноо
олж мэдсэндээ бахархана...” хэмээн Оролмаагийн сэтгэл санааны ертөнцийг
үглэл яриа⁸-ны хэлбэрээр нээхдээ ойролцоо өгүүлбэрийг ашиглан санаагаа
лавшруулсан аж.

Монгол хэлний ойролцоо хэлц өгүүлбэр нь жүжгийн зохиолд мөн эшилсэн,
зохиосон 2 хэлбэрээр тохиолдож байна. Үүнд:

А. Эшилсэн нь:

Хатан- Хүргэн минь төр байтугай гэрийн хэргийг хөтөлж чадахаа больжээ.
Ер нь цаадуул чинь та нарыг бодоход хөл дээрээ бат гэгчийн зогсчхоод, хэлэх
бодох нь гүйцэгдэхээ больжээ. Зүгээр, Мөнх- Очир минь чи эднийг далласан газар
нь ил гарч, далайсан газар нь далд орж явбал л аминд чинь өлзийтэй байж магад
(Д.Намдаг).

Лосол- Тийм ээ, дараа нь бид бор гэртээ богд, хар гэртээ хаан гэгч болно
(Д.Намдаг).

Б. Зохиосон нь:

Агсам морь төвөгтэй

Архи уусан хэрүүлтэй (6, 146)

↓
Оролмаа-Тэгээд юу юуны урьд амьсгаа дарцгааж үз! Агсан морь алсад хүрч
чаддаггүй гэгчээр амьсгаадсан яриа тогтвортой болж чаддаггүй юм (Д.Намдаг).

Дүгнэлт

1. Ойролцоо өгүүлбэрийг бодит болоод хийсвэр утгын талаас авч үзсэн нь агуулгын талд хамаарах бөгөөд эдгээр нь уг үйл явдал нь нэг юм уу, эсвэл үйл явдлын тухай санаа төстөйд тулгуурлана гэж үзэж болно.
2. Хэлний мэдэгдэхүүн (ономасиология) нь юмыг ангилан үздэг ба хэлний нэгжийн гүн бүтцийг тодорхойлохыг зорьдог тул бодит ойролцоо өгүүлбэр нь зүйлийн үгээр бодит үйл явдлыг давтан, нэг санаа илтгэж байна. Үүгээрээ хийсвэр ойролцоо өгүүлбэрээс ялгагдана. Түүнчлэн бодит ба хийсвэр ойролцоо өгүүлбэрийг бүтээхэд ойролцоо гишүүн чухал үүрэгтэй болох нь хэлний баримтаас харагдаж байна.
3. Бодит ойролцоо өгүүлбэр нь нэг санааг илтгэхийн тулд бодит үйл явдлыг давтан, эс адилтган бүтсэн байдаг бол хийсвэр ойролцоо өгүүлбэр нь бодит санааг хийсвэр санаатай ил ба далд адилтган, улмаар ойролцоо санааг илтгэж байна.
4. Яриа бичигт түгээмэл хэрэглэгддэг монгол хэлний ойролцоо өгүүлбэрийг эшлэхийн зэрэгцээ бэлэн хэлц өгүүлбэрийн санаа болоод хэлбэрийг тухайн өвөрмөц байдалд зохицуулан,

⁸ Үглэл яриа (гр. monos logos) - Ямар нэгэн хариуг харилцагч ба сонсогчоос шаардахгүйгээр өөртөө юм уу бусдад хандаж хэлсэн, нэг талын ганцаарчилсан яриаг үглэл яриа гэнэ (Галбаатар, 2002, 337).

найруулгын онцлог, эсвэл үйл явдал, зохиомж зэргийг дуурайн зохиож, цогцолбор бүтээсэн нь олонтоо байна.

5. Монгол хэлний ойролцоо өгүүлбэр нь уран зохиолын үндсэн төрөл болох яруу найраг, үргэлжилсэн үг, жүжгийн зохиолын зохиомжийн зүйлс (хөрөг дүр, байгалийн зураглал, тодорхойлол, захидал, дотоод яриа, үглэл яриа)-д голчлон санаагаа гүнзгийрүүлэн лавшруулах үүднээс хэрэглэсэн байх бөгөөд ялангуяа яруу найрагт сондгойруулахгүйн ёс буюу тэгшлэх хэлбэрээр, үргэлжилсэн үгийн зохиолд тэгшлэх болоод эс тэгшлэх хэлбэрийг хослуулсан нь нэлээд байна.

Ном зүй

- Базаррагчаа М., Баянсан Ж. (1996). Монгол хэл уран зохиолын лавлах. Улаанбаатар.
- Базаррагчаа М., Мөнгөнцэцэг Б. (2012). Монгол хэлний ойролцоо үгийг мэдэгдэхүүн мэдэхүүн ба хэлэгдэхүүн хэлэхүүний талаас үзэх нь, *Монгол судлал*, XXXIV (360). Улаанбаатар.
- Гаадамба Ш. (1987). Зүйр цэцэн үг. *Аман зохиол судлал*, XVI боть. Улаанбаатар.
- Галбаатар Д. (2002). Уран зохиолын онолын ойлголт, нэр томъёоны тайлбар толь. Токио.
- Ринчен Б. (1967) Монгол бичгийн хэлний зүй, Өгүүлбэр зүй, дөтгөөр дэвтэр. Улаанбаатар.

Abstract

Synonymous sentences had considered according to the fact and opinion so it will be the content side and they will be considered those events based on the one or events which has similar idea.

It can be considered in sentence level -at the highest level of the word. To emphasis it is according to knowledge identical parallelism is usually connected with the rational words which has abstract meaning and illusive rational words also emphasized the meaning what want to say. Synonymous sentences have been used primarily to deepen their ideas in poetry, continuous words, and novels.

As we can see it appears to be Synonymous sentences in Mongolian language can be cited and also meaning and types of the synonymous sentences simulated so that it made the discourse. Synonymous sentences in Mongolian is used mainly in literature genres such as poems, narratives, drama to express the meaning in depth.